



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/НБЗ

Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/31 дүгээртэй Хүнхэр зуслангийн байрнуудын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны захирамжийн 1 дүгээр хэсэгт “Үнэлгээний хорооны дарга: Д.Отгонбаяр -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга” гэснийг “Үнэлгээний хорооны дарга: Б.Алтайбаатар - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга” гэж өөрчилсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Алтайбаатар)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ